



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/149

Улаанбаатар хот

Шууд худалдан авах ажиллагааг
зохион байгуулах Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн өндөрлөгийн цэцэрлэгт хүрээлэнгийн геологи болон геодезийн дүгнэлт гаргах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шууд авах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Гэрэлмаа	Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын захирал
Гишүүд:	Ч.Батхуяг	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын захирал
	Ё.Гэрэлцэцэг	Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан Ахлах мэргэжилтэн
	Ц.Бор	1 дүгээр хорооны иргэн
Нарийн бичиг:	Э.Урансайхан	Худалдан авах ажиллагааны албаны Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Хууль тогтоомжийн дагуу зөвлөхийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсэг (Б.Гэрэлмаа)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

1123000207